

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

УЛС ТӨР

**Ж.ЭРДЭНЭБАТ: ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨСВИЙГ БУУРУУЛАХГҮЙ 18 САР АЖИЛЛАНА**

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

**УСАНД ОСОЛДОЖ, АМИА АЛДААД Л БАЙХ ХЭРЭГ ҮҮ**

V нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

## “ХЭМНЭЛТ”

### ХӨТӨЛБӨРТ ДЭД САЙДУУДЫГ ХАМРУУЛЖ


Н.ПУНЦАГБОЛД

Ж.Эрдэнэбат Ерөнхий сайд өнгөрсөн долоо хоногт төрийн албан хаагчдын зардлаас тэвчиж болох бүхнийг хэмнэх зорилт тавьж, “Хэмнэлт” хөтөлбөрийг гаргаж ирлээ. Энэ бол Монголын төрд сүүлийн жилүүдэд үгүйлэгдэж байсан хамгийн том хөтөлбөр байлаа. Үүнийг зоригтой эхлүүлэхээр болсон одоогийн Засгийн газарт гайгүйхэн үнэлгээ өгчигчмөөр байна. Гэхдээ А бол арай л чангадана. Нэг С орчимд л үнэлэх гээд байгаа юм. Учир нь одоохондоо Засгийн газраас зөвхөн төрийн өмчийн том том компаниудын захирлуудын цалинг л тодорхой хувиар хасахаар болоод байна. Цалингаа хасуулах гэж байгаа нөхдүүд нь сардаа 5, 10, цаашлаад 30-аас дээш сая төгрөгийг цалин нэрээр цүнхлээд л сууж байдаг эрхмүүд. Монголын



төрд юу хийж гийгүүлж, ямар баялаг бүтээж, хувь нэмрээ оруулсан болоод сардаа 30, 40 сая төгрөг авна вэ, тэд. Ийм хүмүүсийн цалинг 60 хүртэл хувиар бууруулахаар болсон учраас одоогийн Засгийн газарт С үнэлгээ өгөөд байна. Ер нь бол манай улсад хэмнэж болох үргүй зардлууд маш их байгаа. Тухайлбал, яам, тамгын

газруудад байгаа хийх ажлаа олж ядсан олон төрийн албан хаагч бий. Сүүлийн хэдэн жил “хэрүүлийн алим” болчихоод байсан дэд сайдын суудал ч үүнд багтана. Тэртэй тэргүй дэд сайдын суудал албан тушаалын наймааны хэрэгсэл болчихоод байгааг хэн хүнгүй л мэдэж байгаа шүү дээ. Тэр дундаа сонгуулийн өмнө тарсан, одоо хууль хяналтын байгууллагынхны эвлүүлэг гэж “зүтгэсэн” бичлэг ч үүнийг баталчихсан. Яах вэ,



Дугаарын 60 мөр

Шөнийн үйлчилгээ хэрэгтэй байна

Ж.ОТГОНМЯГМАР

Нэг саяас дээш иргэнтэй хотыг “мега хот” гэдэг жамаар Улаанбаатар ч “мега хот” гэдгээ зарлаад байсан. Нэгэнт нэг сая гаруй хүн амтай “мега хот” учир нийтийн тээвэр нь дэлхийн том хотуудын ерөнхий жишигт хүрсэн байх ёстой. Гэвч манайд энэ асуудал бараг орхигдсон гээд хэлчихэд хилсдэхгүй. Бараг гэсний учир нь Э.Бат-Үүл хотын дарга байхдаа хараалгаж, ерөөлгөн байж, нийтийн тээврийн үйлчилгээнд “Ухаалаг систем”-ийг нэвтрүүлснээр автобусанд суух гэж алаан болдог үе өнгөрсөн. Гэхдээ одоо нийтийн тээвэрт үүнээс өөр гялайж гялтайх юм алга. Энэ өмчлөлтийг хийхэд бүх зүйл сайхан байгаагүй гэдгийг хүн бүхэн мэдэж байгаа.

Төгсгөл нь III нүүрт

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

## Л.МӨНХЗУЛ: Өрхийн мэдээллийн санг шинэчлэх бэлтгэл ажил хангагдсан

М.ДАВАА

Засгийн газар, түүний салбарын яамдаас нийт хүн амд чиглэсэн үйлчилгээ, тусламжийг зорилтот бүлэгт чиглүүлэх үндсэн шаардлагын дагуу Өрхийн мэдээллийн нэгдсэн сан дахь өрх, хүн амын мэдээлэлд үндэслэн зорилтот бүлгийг оновчтой сонгох механизмыг бүрдүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж байна. Тиймээс энэ асуудлын хүрээнд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л.Мөнхзултай ярилцлаа.

Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт олгох тухай асуудлын талаарх ерөнхий мэдээлэл өгөөд ярилцлагаа

эхлэх үү? -Монгол Улсын Засгийн газраас нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэх, улмаар тусламж шаардлагатай

өрх, хүн амд чиглэсэн үйлчилгээг олон салбар (боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, барилга хот байгуулалт, дэд бүтэц, хөдөлмөр, хөдөө аж ахуй гэх мэт) нэг эх үүсвэр бүхий мэдээллийн санг ашиглан хүргэж, үйлчилгээ, тусламжийн давхардлыг арилгах, үйлчилгээний ил тод байдлыг хангах, улмаар тусламж шаардлагатай хүн амыг тусламжийн гадна үлдэхгүй байх боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Үргэлжлэл нь IV нүүрт

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА



улсын нийслэл Ташкент хотноо амжилттай болж өндөрлөсөн. Уг хуралдааны үеэр Монгол, Орос, Хятадын хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт гурван улсын төрийн тэргүүн нар гарын үсэг зурсан билээ. Энэхүү хөтөлбөрт тусгагдсаны дагуу “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэр гүйцэтгэх тухай” Монгол, Орос, Хятадын Засгийн

## ГУРВАН УЛСЫГ ХОЛБОСОН ЭДИЙН ЗАСГИЙН ГҮҮР НЭЭГДЛЭЭ

Н.БАТЗАЯА

Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын зөвлөлийн 16 дугаар хуралдаан өнгөрсөн зургадугаар сард Узбекистан

газар хоорондын хэлэлцээр байгуулах юм.

Үргэлжлэл нь IV нүүрт

ОЛОН ҮЙЛДЭЛТ  
УХААЛАГ ЧАНААГЧ

• Будаа агшаагч • Бялуу жигнэгч • Халуун тогоо • Битүү чанагч

ХААН банк				Хугалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2250.00	2273.00	ФУНТ	2908.00	3008.00	АМ.ДОЛЛАР	2252.00	2278.00
ЕВРО	2524.00	2592.00	РУБЛЬ	33.10	37.80	ЕВРО	2502.00	2636.00
ИЕН	22.26	22.91	ЮАНЬ	338.00	345.90	ИЕН	22.00	23.35
						ФУНТ	2903.00	3055.00
						РУБЛЬ	33.09	38.74
						ЮАНЬ	338.30	345.90

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар



# УЛС ТӨР

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

...Үр дүн нь гарахгүй ажлыг манай Засгийн газар ярихгүй. Хийх ажлаа л ярина. Хийх ёстой ажлаа хийгээгүй бол хариуцлага тооцож ажиллана. Энэ зарчмыг бүх салбарынханд адил тэгш баримтална. Засгийн газрын гишүүддээ ч ийм шаардлага тавьж байгаа” гэв...



# Ж.ЭРДЭНЭБАТ: ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨСВИЙГ БУУРУУЛАХ ҮЙ 18 САР АЖИЛЛАНА

### Ж.ОТГОН

*Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг боловсруулж байгаатай холбогдуулан Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, БСШУС-ын сайд Ж.Батсуурь нар эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, спорт, шинжлэх ухааны салбарын төлөөлөлтэй уулзлаа.*

### “Эрүүл мэндийг дэмжих сан” байгуулахыг Засгийн газар дэмжинэ гэв

Эрүүл мэндийн салбарынхангай уулзсан уулзалтад нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, төрийн бус байгууллагууд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, хувийн хэвшлийн

эмнэлгийн удирдлагууд болон салбарын сайд, эмнэлгийн даргаар ажиллаж асан ахмадууд оролцож, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах санал, тус салбарт тулгамдаж буй асуудлаа ярилаа.

Гурванцагаруйргэлжилсэн уг уулзалтын эхэнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах хүрээнд боловсрол, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарынхангай уулзалт хийгээд байна. Засгийн газар салбар бүрийн дуу хоолойг сонсч, төр, засгийн шийдвэрт тусгаж ажиллана. Ямар ч төр, Засгийн газарт ард иргэдийн эрүүл мэнд хамгийн чухал. Та бүхний ярьсан, хэлсэн саналыг үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгана гэлээ. Манай улсад өнөөдөр хөтөлбөр, төлөвлөгөө, зорилго, зорилт гэсэн нэр бүхий бичиг цаас хангалттай олон байна. Харамсалтай нь ажил болохгүй байна. Боловсруулах ёстой л гэдгээс бус хэрэгжүүлэх учиртай гэж хэн ч ажиллахгүй байна. Үр дүн нь гарахгүй ажлыг манай Засгийн газар ярихгүй. Хийх ажлаа л ярина. Хийх ёстой ажлаа хийгээгүй бол хариуцлага тооцож ажиллана. Энэ зарчмыг бүх салбарынханд адил тэгш баримтална. Засгийн газрын гишүүддээ ч ийм шаардлага тавьж байгаа” гэв. Уулзалтын үеэр салбарын төлөөлүүд Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгуулах зорилгоор өөрсдийн саналыг хэлсэн юм. Тухайлбал, ХӨСҮТ-ийн Ерөнхий захирал Д.Нямхүү “2000 онд Дархлаажуулалтын хууль баталж, сан байгуулсан. Гэтэл 2015 онд “Дархлаажуулалтын сан”-г татан буулгасан. Энэ санг эргүүлэн сэргээх нь маш чухал. Хоёрдугаарт, ДОХ, сүрьеэтэй тэмцэх үндэсний хороо байгуулаар байна. Гуравдугаарт,

“Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг бид боловсруулсан. Засгийн газар үзэж танилцаад, батлах юм бол 2020 он хүртэл хэрэгжих боломжтой” гэлээ. Харин АШУҮИС-ийн Эмнэл зүйн асуудал эрхэлсэн дэд захирал Д.Даваадорж “Манай их сургууль Японы Засгийн газрын тусламжаар эмнэлэг барьсан. 2018 онд ашиглалтад орно. Энэ эмнэлэг нь Баянзүрх дүүргийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх боломжтой. Хоёрдугаарт, манай сургууль сүүлийн хоёр жилийн дотор сургалт, эмнэлзүйн лаборатори байгуулсан. Гуравдугаарт, 2014 онд сургалтын хөтөлбөрөө бүрэн шинэчилсэн. Анхны бүтээгдэхүүн 2017 онд гарна. Ингэснээр иргэдэд чанарын илүү төвшинд хүрч үйлчлэх боломж бүрдэх юм. Төгсгөлд нь хэлэхэд их сургуулийн эмнэлгийн статусын асуудлыг Засгийн газар ярих байх гэж найдаж байна” хэмээсэн юм. Тэгвэл Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Л.Насанцэнгэл “Манай төвд мансууруулах бодис хэрэглэж, гэмт хэрэгт холбогдсон өвчтөн эмчлүүлэх нь сүүлийн гурван жилд эрс нэмэгдсэн. Тиймээс энэ асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн яам, цагдаагийн газар холбогдох байгууллагатай хамтарч ажиллах хэрэгтэй байна. Хоёрдугаарт, сэтгэцийн эмгэгтэй хүний асрамжийн төв байгуулах хэрэгтэй байна. Энэ төвийг Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс удаа дараа шаарддаг. Иймд дээрх хоёр асуудал дээр анхаарал хандуулаар байна” гэх мэтээр салбар бүрийн төлөөлөл асуудлаа танилцуулсан юм.

Энэ үеэр “Эрүүл мэндийг дэмжих сан” байгуулах саналыг олон хүн хэлж байлаа. Тиймээс энэхүү санг байгуулахыг Засгийн газар

дэмжихээр болсон юм. Гэхдээ төсвөөс санхүүжүүлэхгүй. Хувийн хэвшил, гадаад дотоодын хандивлагч байгууллагуудтай зөвшилцөөд ажиллуулж болно гэлээ. Уулзалтын үеэр Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Зүү, тариурын үйлдвэр байгуулахад Эрүүл мэндийн яамнаас дэмжих ажиллахыг А.Цогцэцэг сайдад үүрэг болголоо. Түүнчлэн Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат “Манай улсын эдийн засгийн нөхцөл туйлын хүнд байгаа. Төсвийн шинэчлэлтийг хийгээр энэ хүндрэлээс гарахгүй. Гэхдээ манай Засгийн газар ямар ч тохиолдолд эрүүл мэндийн салбарын төсвийг бууруулахгүй 18 сар ажиллана. Энэ хугацаанд Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд эдийн засагт нааштай өөрчлөлт гарна гэж бодож байна. Эдийн засгаа тогтворжуулсны дараа эмнэлгийн засвар үйлчилгээ, шинэ тоног төхөөрөмж авах, эмч, ажилтнуудын цалин, нийгмийн хамгааллын асуудалд анхаарч ажиллана” гэдгийг онцоллоо.

### “Засгаас мөнгө нэхэхгүй хямд зардлаар асуудлыг зохицуулах боломж байна”

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж байгаатай холбогдуулан салбар бүрийн төлөөлөлтэй уулзах, санал хүсэлтийг тусгах хүрээнд боловсрол, соёл урлаг, спорт, шинжлэх ухааны салбарын төлөөлөлтэй Ерөнхий сайд уулзсан юм.

Уулзалтад оролцогсод өөрсдийн хариуцсан салбар, байгууллагынхаа өнөөгийн байдлыг танилцуулж, цаашид яаж хөгжүүлэх санал санаачил-

гаа Засгийн газрын тэргүүнд дуулгасан юм. Тухайлбал, Шинжлэх ухааны салбарын тухайд гэвэл энэ салбарыг төлөөлж ирсэн эрдэмтэд МАН-ын мөрийн хөтөлбөрт шинжлэх ухааны салбарт зарцуулах төсвийг тав дахин нэмэгдүүлэхээр тусгасан нь бидний урам зоригийг сэргээсэн гэдгийг дуулгалаа. Учир нь энэ салбарт ажиллаж байгаа судлаачдын тоо Ази тивийн дунджаас гурав дахин бага бол энэ салбарт төрөөс зарцуулж байгаа төсөв хөрөнгө 10 дахин бага байдаг байна. Эдийн засгийн хүндрэлтэй байдлыг эрдэмтэд ойлгож байна. Салбарын нөөц бололцоог ашиглаад санхүүжилтийн өөр эх үүсвэр бүрдүүлэх, гадаадаас санхүүжилт татах зэрэг арга хэмжээ авах хэрэгтэй гэлээ. Хамгийн гол нь боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын салбарыг Монгол Улсын тэргүүлэх салбар болгох хандлагыг бий болгох хэрэгтэйг онцоллоо. Харин Боловсролын салбарынхан Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого батлагдсан. Энэ Засгийн газрын үед бодлогын ерөнхий чиглэл цаашид үргэлжилнэ гэдэгт итгэж байна. Төрийн өмчит их, дээд сургуулиудын тухайд оюутны сургалтын төлбөрөөр санхүүждэг. Сургалтын төлбөрийн хэмжээгээр дээд сургуулиудыг санхүүжилтээр хязгаарлах нь олон улсын хэмжээний их сургууль болж хөгжих боломжийг хааж байна. Иймд оюутан бүрт ногдох хувьсах зардлыг төрөөс шийдэж өгөх хэрэгтэйг онцолсон. Түүнчлэн хувийн хэвшлийн сургуулиудын тухайд бодлогын гадна үлддэг сул тал байгааг Засгийн газрын тэргүүнд дуулгалаа.

Соёл, урлагийн салбарын тухайд Соёлын тухай хуулиар боломжийн эрх зүйн орчин бүрдсэн ч тухайн салбарт ажиллагсадны нийгмийн хангамжтай холбоотой заалт

хэрэгжихгүй байгааг дуулгалаа. Энэ салбарын боловсон хүчний асуудалд сүүлийн жилүүдэд намын томилгоо ихээр орж байгааг шүүмжиллээ. Харин Нийтийн биеийн тамир, спортын салбарынхан спорт, нийтийн биеийн тамирыг тусдаа дээвэрт багтаасны үр дүнд нийтийн биеийн тамирын салбар спортодоо дарагдаж хөгжиж чадахгүй байгааг тус салбарын удирдлага хэлж байв. Энэ Засгийн газрын хувьд дээр хоёр салбарыг нэг дээвэр дор нэгтгэж, бүтцийн өөрчлөлт хийсэн. Нийтийн биеийн тамир, спортын сан байгуулах гэж байгаад талархалтай хандаж байгаагаа энэ салбарынхан дуулгалаа. Үүний дараа Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат “Эдийн засаг хүндрэлтэй энэ үед төр, засгаас мөнгө нэхэх биш, хямд зардлаар асуудлыг зохицуулах боломж байна. Тухайлбал, ХНХЯ, ГХЯ барилга дотроо зохицуулалт хийж, ажилтнуудынхаа хүүхдийн цэцэрлэгийн асуудлыг шийдсэн байна. Ийм жишгийг хэвшүүлэх нь зөв. 2017 оноос эхлэн ашиглалтад орх орон сууцны хороолол болон байруудад хүүхдүүдийн цэцэрлэгийн асуудлыг давхар шийдэх стандарт мөрдөх, Засгийн газрын хэрэгжүүлэх чухал асуудлын нэг нь үйлдвэржилтийн бодлого. Шинжлэх ухааны байгууллагууд хувийн хэвшилтэй хамтарч ажиллах хэрэгтэй. Түүнчлэн Засгийн газар спорт, соёл урлагийг хөгжүүлэх, гадаадын өндөр хөгжилтэй улс орнуудад сурч байгаа оюутнуудын эгнээнд энэ салбарын боловсон хүчний тоог нэмэгдүүлэх зэрэгт анхаарч ажиллана” гэлээ. “Салбар, салбарын ийм уулзалтыг жил бүр зохион байгуулна. Өнөөдөр энд ярьсан санал, зөвлөмжийг хэрхэн ажил хэрэг болгосон болон уулзалтын үр дүнг эргэж ярьж байна” гэж Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат уулзалтын төгсгөлд онцолсон юм.

**МОНГОЛЫН МЭДЭЭ**  
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 88873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчлаганы алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**

**Э.САЙНЗАЯА 99197866**

Дугаарыг эрхэлсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

### МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

#### Шилжилт хөдөлгөөнийг зогсоолоо

Орон нутгийн сонгууль болох гэж буйтай холбогдуулан хуульд заасны дагуу өнгөрсөн баасан гарагаас эхлэн иргэдийн шилжилт хөдөлгөөнийг сонгуулийн санал авсны дараах өдөр хүртэл хаагаад байна. Сум, дүүргийн ИТХ-ын сонгууль ирэх аравдугаар сарын 19-ний өдөр бол-

но. Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 66.1 дэх хэсэгт иргэдийн засаг захиргааны нэг нэгжээс өөр нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө түр зогсоож, санал авах өдрийн дараах өдөр сэргээн гэж заасан байдаг билээ.

#### Монголбанкийг удирдах захирлууд тодров

Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурал болж, мөнгөний бодлогын хүүг 4.5 нэгж хувиар буюу 15 хувь болгон нэмэгдүүлснээ мэдэгдсэн. Тэгвэл тус банкнд нэлээд томилгоо хийгдэж, зарим захирлыг шинээр томилогджээ. Тухайлбал, Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч О.Эрдэмбилэг, Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Э.Батшугар, Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Зах зээлийн газрын захирал - Б.Батдаваа, Хяналт, шалгалтын газрын захирал Н.Батсайхан томилогдсон байна. Түүнчлэн Төлбөр тооцоо, бүртгэлийн

газрын захирал М.Амгалан, Судалгаа, статистикийн газрын захирал Ц.Мөнхбаяр, Мөнгөн тэмдэгт, үнэт зүйлсийн газрын захирал П.Сүхбаатар, Мэдээллийн технологийн газрын захирал Д.Довчинбазар, Эрсдэлийн удирдлагын албаны захирал А.Энхжин, Ерөнхийлөгчийн зөвлөх бөгөөд Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир нар тус тус томилогджээ. Харин одоогоор Монголбанкны Тамгын газрын захирал, Дотоод Хяналт, Үйл ажиллагааны эрсдэлийн газрын захирал, Хууль, эрх зүйн газрын захирлын нэрс тодроогүй байгаа аж.

#### Ээлжит бус чуулган пүрэв гарагт хуралдаж магадгүй

УИХ-ын ээлжит бус чуулганыг яаралтай хуралдуулахыг Ардчилсан намын бүлгээс шаардсан. Улсын төсөв, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлаас улбаалж төсвийн тодотгол хийх шаардлагатай байгаа юм. Тэгвэл энэ сарын 25-нд буюу энэ пүрэв гарагт ээлжит бус чуулганыг зарлаж магадгүй байгаа аж. Нэгдсэн хуралдаанаар өнгөрсөн оны төсвийн тайлан, 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2020 он хүртэлх дунд хугацааны хөтөлбөрийн гол параметруудыг батлах юм. Түүнчлэн төсвийн тодотголыг хийх учиртай.

**МАН-ынхны хүүхдүүд яамны цэцэрлэгт явах нь, харин ардын хүүхдүүд...**

ЗГХЭГ-ын дарга, УИХ-ын гишүүн Ж.Мөнхбат өөрийн нүүр номондоо “Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд ажилчдынхаа хүүхдүүдэд зориулж дотооддоо цэцэрлэг байгуулах тухай санаачилга маань Засгийн газрын хуралдаанаар дэмжигдлээ. Эхний ээлжинд ГХЯ, ХНХЯ, Уул уурхайн яамдууд яамныхаа байранд 70-80 хүүхдийн нийт 230 хүүхдийн цэцэрлэг байгуулахаар боллоо” хэмээн бичсэн юм. Ийнхүү ардын хүүхдүүд сугалаагаар, МАН-ын хүүхдүүд яамны цэцэрлэгт явна гэх Ж.Мөнхбатын мэдээлэл олон нийтийн шүүмжлэлд өртөөд байна. Харин үүний харинд УИХ-ын гишүүн С.Эрдэнэ “Арай үгүй байлгүй дээ. Хүүхдийн стандарт орчин гэж бий? Дээр нь наад байрууд тань тусгай хамгаалалттай газар” хэмээн жиргэжээ. Түүнчлэн сошиал орчинд “МАН-ын гишүүдийн хүүхэд ЯАМ-ны цэцэрлэгт явах нь, “Нэг талаас цэцэрлэгийн асуудлыг шийдэж байгаа ч нөгөө талдаа төрийн албаны ханшиг өсгөж, авлигыг улам гааруулж байна” гэх зэргээр шүүмжлэл өрнөсөөр байна.

**МАН-ынхны хүүхдүүд яамны цэцэрлэгт явах нь, харин ардын хүүхдүүд...**

Мункбат. Jamiyan @Munkbat\_UNEN 2h  
Төрийн Байгууллагын байранд хүүхдийн цэцэрлэг б/гуулах саналыг минь ЗГ дэмжиж ГХЯ, ХНХЯ, ууя-д байранда 230 хүүхдийн цэцэрлэг б/гуулах болов

С.Эрдэнэ @serdenem  
@Munkbat\_UNEN @nyamka0115  
Арай үгүй байлгүй дээ. Хүүхдийн стандарт орчин гэж бий? Дээр нь наад байрууд чинь тусгай хамгаалалттай газрууд?!

Translate from Russian  
8/19/16, 7:44 PM



# ҮЗЭЛ БОДОЛ

## “ХЭМНЭЛТ”

### хөтөлбөрт дэд сайдуудыг хамруулъя

Дугаарын **60** мөр

### Шөнийн үйлчилгээ хэрэгтэй байна

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт



Х.Булгантуяа Сангийн дэд сайд | Б.Энхбаяр ХЗДХ-ийн дэд сайд | Б.Мөнгөнчимэг ХНХ-ын дэд сайд | Б.Батцэцэг ГХ-ийн дэд сайд | Т.Дуламдорж БХ-ын дэд сайд | Ц.Батбаяр БОАЖ-ын дэд сайд | Е.Отгонбаяр БСШУС-ын дэд сайд | Ш.Ахамсүрэн БХБ-ын дэд сайд



Б.Цогтгэрэл ЗТ-ийн хөгжлийн дэд сайд | Ж.Сауле ХХААХУ-ийн дэд сайд | Х.Бадамсүрэн УУХУ-ийн дэд сайд | Л.Бямбасүрэн ЭМ-ийн дэд сайд | М.Батбаяр БХБ-ын дэд сайд | Т.Гантулга Эрчим хүчний дэд сайд

#### Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Гэхдээ заавал дэд сайдын гэх хэрэггүй, хиймэл албан тушаал бий болгож, улсын төсвийг үргүй зарж, “бялуу” хүртээх шаардлага байгаа юм уу. Өөр өчнөөн л албан тушаал, ажил байна шүү дээ. “Шийдийн” Засгийн газрын үед нэг дэд сайд сардаа 4-4.5 сая төгрөгийн зардалтай гэх тоо баримтыг гишүүд ярьж байсан. Сайдын сарын цалин 1.4 сая төгрөг, цаашлаад туслах, жолооч, утас, шатахуун гэх мэт зардал нь нийлээд 4-4.5 сая төгрөг болдог байсан юм байх. Ингээд тооцоод үзэхээр тухайн үед 17 дэд сайдыг цомхотгосноор улс 800 саяас нэг тэрбум хүртэлх төгрөгийн зардлыг хэмнэж байжээ. Тэгвэл одоо 15 дэд сайдыг “Хэмнэлт” хөтөлбөрт хамруулаад, сандлаас нь буулгачихвал улс жилдээ 600-800 орчим сая төгрөгийн зардлыг хэмнэж болохоор байгаа юм. Өмнөх жишигт нийцүүлж тооцож үзвэл шүү дээ. Гэхдээ одоо дэд сайдын цалин хэд болж нэмэгдэж байгаа юм, урсгал зардал нь яаж дээшилснийг яг таг хэлэхэд хэцүү. Магадгүй 15 дэд сайдыг буцааж татсанаар жилдээ тэрбумаас илүү ч төгрөг хэмнэж болох юм. Энэ чинь хангалттай л хэмнэлт шүү дээ. Ядаж л нэг цэцэрлэг барьчих мөнгө. Ардын хүүхдүүд цэцэрлэгийн хүрэлцээгүйн улмаас гэртээ цоожлогдож байна. Эсвэл залуу гэр бүлүүд хоёр эрэг ажиллаж, амьдралаа өөд нь татах

боломжоо хумсалж байна. Үр хүүхдээ аюулгүй өсгөхийн төлөө ээжүүд гэртээ хэдэн жилээр ч хамаагүй сууж байгаа. Зарим нэг дарга нар “Тэрбум төгрөгийн хэмнэлтийг ямар хэмнэлт гэх юм. Ийм бага мөнгөөр юу ч хийж чадахгүй” гэж хэлж магадгүй. Тэгвэл бүтэн сар зүтгэж байж 500-600-хан мянган төгрөгийн цалин авч байгаа алтан дундчууд, үүнээс ч бага орлоготой ядууст тэрбум гэдэг чинь сонсоод ч айхаар их мөнгө. Зөв зарцуулж чадвал их зүйл хийж болохоор мөнгө шүү дээ. Ерөнхий сайд хүүхдүүдэд сард өгч байгаа 20 мянган төгрөгийг хасна, танана гэж ам ангайсан байсан. Яг зорилгот бүлэгт л өгөх юм байх. Гэхдээ том зурагт, хөргөгч, угаалгын машин, тоос сорогчтой юу гэж асууж байгаад, байвал хүүхдийн мөнгийг нь хасаад байвал тэнэг л байх. Өнөө “Сайхан хүүхэн болгоныг бариад байх хэрэг үү” гэдэг шиг л юм болно. Уг нь манайх шиг олуулаа болох гэж ядаж байгаа улс оронд төрөлтийг дэмжих нэг ч болов хөтөлбөрөөр байвал зүгээр л байх. Одоохондоо төрөлтийг дэмжиж байгаа гэж гүүтгэж болохоор хөтөлбөр нь сар бүр хүүхдэд өгч байгаа 20 мянган төгрөг. Гэтэл үүнийг нь цахилгаан бараатай эсэхийг нь асуугаад л хасчихвал үнэхээр онгоо байна. Хэрвээ дэд сайдуудаа буцааж татчихаад хэмнэсэн мөнгөөр нь хэдэн

хүүхдэд ч болов сарын 20 мянган төгрөг өгчихөж болох л байх. Ийм л зөв бодлогыг эрх баригчид хэрэгжүүлэх хэрэгтэй. Түүнээс биш улс орон дампуурч байна гэж баахан түйвээж, хэмнэнэ гэж довчигночихоод, сайдуудынхаа тоог нэмж, хэрэгтэй хэрэггүй албан тушаал бий болгож, тэртэй тэргүй хөлжчихсэн хүмүүсийг төр тэжээх нь зөв бодлого биш л болов уу. Төр татвар төлөгчдийн мөнгийг харамлах хүнээсээ харамлаад, өгөх хүндээ өгөх л хэрэгтэй. Дэд сайдуудаас бол харамлааар л байна. Үнэхээр л тэгж албан тушаалынх нь нэр хэрэгтэй байгаа бол цалингүй, туслахгүй, жолоочгүй ажиллаач дээ. Ямар дэд сайдад хийх ажил байх биш. Сайд, төрийн нарийн хоёрын дунд хавчуулагдсан нэр төдий л албан тушаал. Ямар ч эрх мэдэл байхгүй. Яах вэ, хааяа нэг тууз хайчилдаг л байх. Өнөөдөр дэд сайдыг тоодог хүн байгаа юм уу. Одоо бүр ч тоохоо больсон. Тэртэй тэргүй мөнгөөр худалдаж авсан нэр төдий л албан тушаал гэдгийг нь мэддэг болчихсон юм чинь. Тийм болохоор намтар дээрээ “дэд сайд” гэсэн тодотгол бичүүлэх хүсэлтэй хүмүүс байгаа бол цалингүй, мөнгөгүй ажилладаг нь хаашаа юм. Түүнээс биш татвар төлөгчид юу ч хийдэггүй хүнд сард сая хол давсан цалин өгч, тусгай хангамж эдлүүлээд байхыг хүсэхгүй л байна. Тиймээс Ж.Эрдэнэбат сайд хэл амны бай болсон хэдэн дэд сайдынхаа асуудлыг эртхэн шийдчихсэн

...Ямар дэд сайдад хийх ажил байх биш. Сайд, төрийн нарийн хоёрын дунд хавчуулагдсан нэр төдий л албан тушаал. Ямар ч эрх мэдэл байхгүй. Яах вэ, хааяа нэг тууз хайчилдаг л байх. Өнөөдөр дэд сайдыг тоодог хүн байгаа юм уу. Одоо бүр ч тоохоо больсон. Тэртэй тэргүй мөнгөөр худалдаж авсан нэр төдий л албан тушаал гэдгийг нь мэддэг болчихсон юм чинь. Тийм болохоор намтар дээрээ “дэд сайд” гэсэн тодотгол бичүүлэх хүсэлтэй хүмүүс байгаа бол цалингүй, мөнгөгүй ажилладаг нь хаашаа юм...

нь дээр биз дээ. Хэмнэх гэж байгаа юм бол хийсэн шиг л хий. УИХ-ын гишүүд ч гэсэн тусгай хангамжаасаа татгалзахад яах вэ дээ. Цалингаа бол авдаг л юм байгаа биз. Утас, унаа гээд бусад тусгай хангамжуудаасаа сайн дураараа татгалзчихаач дээ. Ямар машинныхаа шатахуун, утасныхаа төлбөрийн мөнгийг дийлэхгүй л гишүүн байв гэж дээ. Ядаж байхад бүгд хувьдаа бизнестэй, хэт баяжихсан хүмүүс байгаа биз дээ, тэд чинь. Тийм байж иргэдийнхээ татварын мөнгөөр утасныхаа төлбөрийг төлүүлж, унааныхаа зардлыг даалгахаас жаахан ч гэсэн ичмээр юм.

Анх төв замын нэгдүгээр эгнээг автобусанд чөлөөлж өглөө гээд бас л хараал ерөөл болж байсан. Дараа нь цахим төлбөрийн системд шилжлээ гээд мөн л хэл ам дагуулж байсан. Хэл ам, хараал уцаартай эхэлсэн шинэчлэлийн үр дүнд одоо харин нийслэлийн иргэд, уур уцаар багатай нийтийн тээвэрээр үйлчлүүлэх болсон нь үнэн. Гэрэл гэгээтэй буудлаас тохилог цэвэрхэн автобусанд суугаад, кондукторт хараалгаж, чичлүүлэггүй картаа уншуулаад, нэгдүгээр эгнээгээр сүнгэнээд л хүрэх газраа хүрчихэж байна. Энэ бол их хотын өдрийн амьдрал.

Тэгвэл Улаанбаатарын иргэд оройн 21:00 цагаас эхлээд явгардаг бүрхэг байдал хэвээр байна. Уг нь 2015 онд “Шөнийн нийтийн тээвэр”-ийн эхлэлийг тавьсан. Тодруулбал, түлшээр бус цахилгаанаар явдаг троллейбусыг шөнийн цагаар үйлчилгээнд явуулсан нь энэ. Гэтэл “Иргэд үйлчлүүлэхгүй байна” гэх шалтгаанаар нэг их удалгүй уг үйлчилгээ зогсчихсон. Учир нь иргэдэд хамгийн их хэрэгтэй чиглэл бус зөвхөн төв замаар явдаг чиглэлд явуулсантай шууд холбоотой. Гэтэл худлаа үнэн тохилог орон сууцанд буюу нийслэлийн А зэрэглэлд амьдарч байгаа хүмүүс юу гэж л тэр автобусаар үйлчлүүлэх билээ. Өөрийн гэсэн машинтай буюу боломжийн амьдралтай хүмүүс байх нь ойлгомжтой. Хэрвээ тухайн үйлчилгээг гэр хорооллын чиглэл буюу Долоон буудал, Ханьн материал, Зүүн салаа, Баянхошуу, Толгойт, Баруун, Зүүн салаа, Нисэх, Орбит, Тахилт гээд хамгийн их хүн үйлчлүүлж болох чиглэлд явуулсан бол өөр хэрэг. Магадгүй өдөр үйлчлүүлдгээс ч их хүн суух магадлалтай. Харин эдгээр чиглэлд одоо өнөөх насжилт нь дууссан хэмээн үйлчилгээнээ “хөөгдсөн” микро автобусууд хулгайгаар үйлчилж байв. Нэг талаар эдгээр микро автобусны кондукторуудыг амандаа багтсан үнээ хэлж, иргэдийг элдэв янзаар загнаж, доромжилдог гэх шүүмжлэл дагадаг ч нөгөө талаар шөнийн цагаар явгарчидгад, таксины мөнгөгүй иргэдийг “хямд үнэ”-ээр гэрт нь дөхүүлдэг “буянтай хүмүүс” гэлтэй. Гэвч хулгайн микронууд хуардсанаас хойш дээр нэрлэсэн гэр хорооллын иргэд гэртээ харих унаагүй болж, ганц ирсэн микронд гар хөлөө чилтэл ч хамаагүй зогсоогоороо үйлчлүүлж байна. Төрийн албаныхнаас бусад нь ажилласан цагаараа хөлсөө авах гэж улайрч хөдөлмөрлөсөөр 22:00 цаг дөхүүлдэж тарж байгаа ч хүн их бий. Гэтэл нийтийн тээврийн том оврын автобусууд 22:00 цагтай уралдаад буучихаар хүмүүс явгарахаас ч яах вэ дээ. Дээрээс нь нийслэлчүүд үүрийн 04:00 цаг хүртэл унтахгүй байх “эрхийн бичиг”-тэй болчихсон. Өөрөөр хэлбэл, нийслэлийн Засаг даргын захирамжаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий үйлчилгээний газруудын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг шөнийн 04:00 цаг хүртэл болгосон. Тиймээс ч толгой өндийх завгүй өдөржин ажилласан залуус ажлын стрессээ тайлахаар эдгээр газарт найз, нөхдөрөө уулзаж, суудаг болоод байгаа. Мэдээж манай Улаанбаатар томоохон хот болон өргөжиж байгаа учраас үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд иргэдийн өөрсдийн ажил амьдрал эрс өөрчлөгдөж байгаа гэдгийг мэдэхгүй хүн байхгүй. Иймээс аль ч талаа бодсон, нийтийн тээврийн цагийн хуваарьт өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Мандуулна, жаргаана гэсэн хүмүүс энэ мэт асуудалдаа анхаарчихвал ядарсан иргэд чинь талархах нь дамжиггүй.



ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ

**MMINFO АПП**

Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...












# ОНЦЛОХ ХУУДАС

## Сенсаацийн эргэн тойронг

# УСАНД ОСОЛДОЖ, АМИА АЛДААД Л БАЙХ ХЭРЭГ ҮҮ

Урин дулааны улиралд иргэд гол ус бараадаж, амарч зугаалах нь ихэсдэг. Энэ үеэр анхаарал болгоомжгүйгээс үүдэлтэй осол гэмтэл, усанд живэх тохиолдлууд эрс нэмэгддэг гэдгийг холбогдох албаныхан анхааруулсаар байгаа юм. Энэ жилийн хувьд хур тунадас ихтэй, гол мөрөн үерлэж, усны түвшин нэмэгдэж байгаа ч анхааруулж, болгоомжтой байхыг сануулж байгаа. Гэвч ойрын өдрүүдэд олон хүн гол усанд осолдож, амиа алдаад байна. Тиймээс энэ удаагийн “Онцлох хуудас” булангаараа дээрх асуудлыг онцолж байна.

### Дахиад бороо орох түл сэрэмжлээрэй

2016.08.21

Цаг уур, орчны шинжилгээний газраас мэдээлснээр энэ сарын 22-нд баруун, төв, говийн аймгуудын зарим газраар бороо, 23-нд ихэнх нутгаар, 24-нд нутгийн зүүн хагаст, 25-нд баруун болон төвийн аймгуудын хойд хэсгээр бороо, уулархаг нутгаар хур тунадас орохыг анхааруулж байна. Салхи 22-нд баруун аймгуудын зарим газраар, 23-нд ихэнх нутгаар, 24,25-нд говь тал хээрийн нутгаар секундэд 16-18 метр хүрч ширүүснэ. 22-нд өдөртөө халуун байх боловч 23-нд нутгийн хойд хэсгээр, цаашдаа ихэнх нутгаар сэрүүсч Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар шөнөдөө 0-5 хэм, өдөртөө 13-18 хэм, говийн бүс нутгийн өмнөд хэсгээр шөнөдөө 13-18 хэм, өдөртөө 22-27 хэм, бусад нутгаар шөнөдөө 3-8 хэм, өдөртөө 16-21 хэм дулаан байна хэмээн мэдээллээ. Нийт нутгаар усархаг бороо орж байгаагаас үүдэн томоохон гол мөрний ус үерийн аюултай төвшинг даваад байгааг ч хэлж байна. Тиймээс бага насны хүүхдээ хараа хяналтгүй гол ус руу явуулахгүй байх мөн насанд хүрсэн хүмүүс өөрсдөө архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гол усанд орохгүй байхыг анхааруулж байна.

### Амралтын өдрүүдэд долоон хүн усанд живж, амиа алджээ

2016.08.15

Иргэд өөрсдийн хайхрамжгүй хэнэггүй байдлаас болж, усанд хөл алдан живэх, осолдох хэрэг гарсаар байна. Өнгөрсөн сард гэхэд хүүхэд, том хүн нийлсэн 40 гаруй иргэн усанд осолдож, амиа алдсан бол энэ наймдугаар сар гарснаас хойш 20 гаруй хүн усанд осолдсон гэх тоо баримт байна. Тухайлбал, энэ амралтын өдрүүдэд гэхэд хүүхэд, том хүн нийлсэн долоон хүн усанд живж харамсалтайгаар амиа алджээ. Тодруулбал, Баянхонгор аймгийн Шинэжинст сумаас 80 км-т Эрдэнэшанд III багийн нутаг Хаамаа голд тус сумын харьяат, 36 настай, эрэгтэй М, 12 настай эмэгтэй Т, 48 настай, эрэгтэй Г, 32 настай, эрэгтэй Г, 15 настай, эрэгтэй Д нарын таван хүн голд живж, нас барсан байна. Мөн Өвөрхангай аймаг Өвөрхангай аймгийн Хархорин сумын Орхон голд, тус сумын харьяат, гурван настай, эмэгтэй Г, нэг настай, эрэгтэй Т нар живж, амиа алджээ.

### Машинтайгаа гол гаталж яваад живжээ

2016.08.16

Иргэд машинтайгаа гол мөрнөөр гатлах гэж яваад живж амиа алдсан харамсалтай хэрэг гарсаар байна. Ихэнх нь гарамгүй газраар өөрсдөө дур мэдэн гарч яваад живдэг аж. Өнгөрсөн амралтын өдөр гэхэд нэг айлын таван хүн машинтайгаа голд живж амиа алдсан хэрэг гарсан бол өчигдөр мөн л нууранд машинтайгаа живсэн хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгджээ. Тодруулбал, Увс аймгийн Улаангом сумын VIII баг Увс нууранд, тус суманд оршин суух 27 настай, эрэгтэй Ө живж нас барсан байна. Ийнхүү иргэд өөрсдийн буруутай үйлдэл хайхрамжгүй байдлаасаа болж, олуулаа буюу гэр бүл, найз нөхдөөрөө аялж зугаалж яваад гол усанд живж осолдох хэрэг олон гарч байгаа тул аялж амарч зугаалж явахдаа, болгоомжтой байхыг цагдаагийн байгууллагаас анхааруулж байна.



### Туул гол дагуу завьт эргүүл ажиллаж байна

2016.08.19

Иргэдийг усны ослоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, тусламж үзүүлэх, иргэдэд сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газраас 21 хоногийн “Болзошгүй усны ослоос урьдчилан сэргийлье” удирдамжийн дагуу нийслэлийн Онцгой байдлын газрын даргын тушаал гарсан. Усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг энэ сарын 05-26-ны өдрүүдэд зохион байгуулж байна. Нийслэлийн хэмжээнд Туул гол дагуу буюу Баянзүрх дүүргийн XX хороо Гачууртын Хадан цохионоос Хан-уул дүүргийн нутаг Яармагийн гүүр хүртэл НОБГ, дүүргүүдийн Онцгой байдлын хэлтэс, Нийслэлийн аврах анги, Гал унтраах аврах ангийн нийт 103 албан хаагч, 14 техник хэрэгсэлтэйгээр өдөр бүр эргүүлж гарч, иргэдийг гол усны аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж байна. Мөн Завьт эргүүл зургадугаар сарын 20-ны өдрөөс есдүгээр сарын 20 хүртэл Туул гол дагуу эргүүлээр ажиллаж байна.

### Онцгойгийнхон 272 хүнийг уснаас аварчээ

2016.08.19

Гол, усны аюулын тоо, хохирлыг бууруулах, ард иргэдийг усны ослоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, тусламж үзүүлэх, иргэдэд сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Онцгой байдлын ерөнхий газраас “Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай”, “Бэлэн байдлыг хангах тухай” албан бичгийг төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, байгууллагуудад хүргүүлэн, үүрэг өгч ажиллажээ. Тэгвэл тус үүргийн хүрээнд Онцгой байдлын газар, хэлтсүүд ОБГ-ын ГХУХ-ийн байцаагчийн албан мэдэгдэл 104-ийг сумдын Засаг дарга нарт хүргүүлж, сэрэмжлүүлэх мэдээллийг мессэжээр 50832 иргэнд хүргэж, 386 удаа үер усны ослоос урьдчилан сэргийлэх сэдвээр сургалт зохион байгуулж, 11586 иргэнийг хамруулсан байна. Мөн төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн албан хаагчид орон нутгийнхаа үер усны аюулд өртөж болзошгүй газруудад 226 усны ослоос урьдчилан сэргийлэх, анхааруулах самбар шинээр байршуулжээ. Гол усны ай сав газар аялал зугаалгаар явж буй иргэд болон зусч байгаа айл өрхүүдийн 43457 иргэнд болзошгүй усны ослоос урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлэг тарааж, үер усанд автаж болзошгүй 250 айл өрхийг нүүлгэн шилжүүлж, 272 хүнийг усанд осолдож эндэхээс аварсан байна. Түүнчлэн голын ай сав газруудад албан хаагчид эргүүл хийх хутагаандаа 26154 иргэнд усны ослоос урьдчилан сэргийлэх талаар яриа таниулгыг биечлэн хийж, заавар зөвлөмж өгч ажиллаж, орон нутгийн мэргэжлийн албадтай хамтран үерийн ус зайлуулах 75 суваг шуудууг сэргээн засварлажээ.

### Голын усанд биш усанд живж, амиа алдав

2016.08.17

Урин дулааны улиралд иргэд гол ус бараадаж амарч зугаалах үедээ анхаарал болгоомжгүй байдлаасаа үүдэн голын усанд осолдон, живж амиа алдах тохиолдлууд эрс нэмэгддэг гэдгийг цагдаагийн байгууллагаас анхааруулж буй. Өчигдөр л гэхэд Налайх дүүргийн I хорооны нутаг, “Туул голын усанд усанд хүн живчихлээ” гэх мэдээллийг цагдаагийн байгууллагад өгсөн байна. Дуудлагын дагуу цагдаагийн алба хаагчид очиж, шалгахад Сүхбаатар дүүргийн XII хороонд суух 23 настай, эрэгтэй Б нь 16:00-16:30 цагийн хооронд голын усанд сэлж байгаад хөл алдан живж нас барсан байжээ. Үүнээс гадна усан санд сэлж байгаад хөл алдан живсэн харамсалтай тохиолдол ч гарсан байна. Тодруулбал, Налайх дүүргийн IV хорооны нутаг, “Төмрийн үйлдвэрийн усан санд манай ажилчин живчихлээ” гэсэн мэдээллийн дагуу цагдаагийн байгууллагынхан шалгахад “...” ХХК-ийн төмрийн үйлдвэрт туслах ажилчин, Говь-Алтай аймаг Эрдэнэ сумын харьяат, 19 настай, эрэгтэй А энэ сарын 16-ны 13:00-14:00 цагийн хооронд үйлдвэрийн усан санд сэлж байгаад хөл алдан живж нас барсан байна. Иймд иргэн та гол, усанд орохдоо анхаарал сэрэмжтэй байж голын гүн хэсэг рүү түүхээр явах нь ихэсч байна. Гэтэл цаг уурын дулааны улиралд хур бороо орж, голын түвшин дээшилдэг учир анхаарал болгоомж илүүдэхгүй гэдгийг санууллаа.

## Сэтгүүлчийн өнцөг

# ХЭНЭГГҮЙ ЗАНГААЛ ХАЯЧИХ

Э.ЭНХ

Өнгөрсөн оны өдийд Архангай аймгийн Тариат сумын Хорго багийн “Сөрт” хэмээх газар, Тэрхийн цагаан нууранд гэр бүлээрээ завьтай зугаалж явсан долоон хүний завь хөмөрч, гурав нь амиа алдсан харамсалтай хэрэг гарч байсан бол хэдхэн хоногийн өмнө Баянхонгор аймгийн Шинэжинст сумаас 80 км-т Эрдэнэшанд III багийн нутаг Хаамаа голд тус сумын харьяат, нэг гэр бүлийн таван хүн живж, нас барсан харамсалтай хэрэг гарлаа. Эхний тохиолдолд гэр

бүлийн долоон хүнд дөрөвхөн аврах хантааз өгч, нуурын гол руу явуулсан хүмүүст хариуцаага тооцохоор харагдаж байгаа хэдий ч манайхны хэнэггүй зантай шууд холбоотой гэхэд хилсдэхгүй. Хэрвээ гадаадад байсан бол хүнийхээ тоогоор аврах хантаазаа нэхэж байгаад авдаг, эсвэл ийм эрсдэлтэй алхам хийхгүй байсан нь мэдээжийн хэрэг. Гэвч манай монголчууд хэзээнээсээ хэнэггүй, хээгүй гэдгээрээ түрий барьж, өөрийгөө ч, өрөөлийг ч эрсдэлд оруулаад байгаагаас мэдсээр байж тоодоггүй. Гэтэл энэ он гарсаар иргэдийн болгоомжгүй

байдлаас шалтгаалан усны ослоор 24 аймгийн 47 сум, нийслэлийн таван дүүргэрт нийт 78 удаагийн тохиолдлоор 93 хүн амь насаа алдаад байна. Үүнээс 31 нь хүүхэд байгаа нь харамсалтай. Энэ тоог өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 24 хувиар өссөн үзүүлэлт хэмээн холбогдох албаны хүн хэлж байна. Бороо хур элбэгтэй жил, гол усны түвшин нэмэгдсэн шүү, бага насны хүүхдийг хараа хяналтгүй битгий орхиорой, найз нөхөд, хамт олноороо аялал, амралт зугаалгаар явахдаа архи согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэж болохгүй гээд л хэчнээн

их хэлж, сануулж, сэрэмжлүүлсэн билээ. Гэвч энэ бүх анхааруулга чихнийх нь хажуугаар өнгөрсөн болоод л эдгээр хүмүүс амь насаа алдсан гээд хэлчихвэл хагуудсан болохгүй. Одоо аялал зугаалгын улирал арай ч дуусчихаагүй, бүр ид үедээ явж байна гэхэд болох биз. Учир нь яг одоо жимс самар боловсорч гүйцэж байгаа болохоор орон нутгийн төдийгүй нийслэлийн иргэд найз нөхөд, гэр бүлээрээ, зарим нь ч ашиг орлогоо нэмэгдүүлэхээр самар, жимс түүхээр явах нь ихэсч байна. Гэтэл цаг уурын байгууллагын ирүүлсэн мэдээгээр ойрын өдрүүдэд дуу

цахилгаантай бороо орох тухай мэдээг байнга ирүүлж, дахиад л сануулаад, сэрэмжлүүлээд эхэллээ. Нэгэнт тохиосон байгалийн давагдашгүй хүчин зүйл, онц аюултай гэнэтийн үзэгдлийг даван туулахад амар биш ч урьдчилан сэргийлж чадвал хохирол багатай давахын зэрэгцээ амь насаа ч алдахгүй байх боломжтой. Гэвч манайхны хэтэрхий хэнэггүй зангийн гайгаар хэчнээн алтан амь үрэгдсэнийг дээр өгүүлсэн шүү дээ. Тиймээс хээгүй, хэнэггүй зангаа гээж, эрсдлийг тооцож, амь нас, гэр бүлээ хамгаалаад сурчих хэрэгтэй байна.



# ДЭЛХИЙ

## БНАСАУ оргосон дипломатчаа “ГЭМТ ХЭРЭГТЭН” ХЭМЭЭ

Их Британид суугаа Элчин сайдын орлогч Тэ Юн Хо гэмт хэрэг үйлдээд шийтгэлээс зугтан Өмнөд Солонгост урвасан гэж БНАСАУ мэдэгдлээ. БНАСАУ-ын КСНА агентлагийн мэдээлснээр Тэ Юн Хо нь төсвийн мөнгийг шамшигдуулж, төрийн нууцыг худалдаж, насанд хүрээгүй хүүхдийг хүчирхийлсэн хэрэгт сэжиглэгдэж байгаа аж. БНАСАУ мөрдөн шалгуулахаар нутагтаа ирэхийг өнгөрөгч зургадугаар сард үүрэг болгосны зэрэгцээ тус улсын Прокурорын Ерөнхий газар түүний хэргийг мөрдөн шалгаж эхлэх шийдвэрийг өнгөрсөн сарын 12-нд гаргасан гэнэ. Гэвч

гэмт хэрэгтнийг хамгаалж, энэ хэргээр далимдуулан БНАСАУ-ын нэр хүндийг унагааж, БНАСАУ-ын эсрэг суртал нэвтрүүлгийг эрчимжүүлэхийг Өмнөд Солонгос улс оролдож байгаад Пхеньяны зүгээс шүүмжлэлтэй хандаж буй мөн мэдэгдсэн байна. Өмнөд Солонгосын Эв нэгдлийн яам өнгөрсөн лхагва гарагт “БНАСАУ-аас Их Британид суугаа Элчин сайдын орлогч гэр бүлийнхэнтэйгээ манай улсын засгийн газрын хамгаалалтад байгаа” хэмээн мэдэгдсэн билээ. Тэ нь Сөүл рүү дүрвэсэн БНАСАУ-ын хамгийн өндөр албан тушаалтан болж байгаа юм.



Улмаар босогчдын хүч суларсан ч, долдугаар сарын 31-нээс хойш дайралтаа эрчимжүүлсэн юм. Түүнээс хойш нийтдээ 333 хүн нас барсан байна. Хохирогчдын 165 нь босогчдын Алеппо хотын баруун этгээдэд өгсөн цохилтоор амиа алджээ. Тэдний 49 нь хүүхэд байсан гэнэ. Харин үлдсэн 168 нь босогчдын хяналтад буй зүүн хэсэгт ОХУ-ын тал болон Сирийн армийнхны өгсөн цохилтоор амь үрэгдсэн байх юм. Ингэхээр дайны хөлөөс зугтаж, Газар дундын тэнгисийг гатлан Европын орныг зорих хүүхдүүд, эх орноо сахиж үлдсэн хүүхдүүд яг адилхан эрсдэлтэй тулгардаг байна. НУБ-ын Хүүхдийн сангаас өгсөн мэдээллээр Алеппо хотын босогчдын хяналт дахь зүүн хэсэгт эдүгээ 250 мянган хүн амьдарч байгаагийн 100 орчим

## Дэлхийн хамгийн урт шилэн гүүр нээлтээ хийлээ



Хятадын Хунань мужийн нутагт орших байгалийн үзэсгэлэн бүрдсэн нутагт жуулчдыг татах зорилгоор 430 метрийн урт шилэн гүүрийг байгуулсан байна. Энэхүү гүүр ашиглалтад орсон даруйд маш олон тооны жуулчид тус нутгийг зорьж очжээ. Гүүр өнгөрсөн бямба гарагт Хунань мужийн Чжанцзяцэ үндэсний цэцэрлэгт хүрээлэнд нээлтээ хийсэн байна. Тус гүүр дэлхийн 10 удаагийн рекорд амжилтыг тогтоосон байна. Гүүрний урт нь 430 метр, өргөн нь метр аж. Шилэн гүүрийг

тус бүртээ гурван хэсгээс бүрдэх 99 тунгалаг шилээр хийсэн бөгөөд хоёр хавцлын дунд 300 метрийн өндөрт байрлуулсан ажээ. Гүүрийг барьсан албаны хүмүүсийн ярьж буйгаар гүүрээр нэгэн зэрэг найман мянган хүн зорчиж болох гэнэ. Гүүрний барилгын ажил өнөрсөн жилийн 12 сард дууссан юм байна.

Чжанцзяцэ үндэсний цэцэрлэгт хүрээлэн нь Хятад төдийгүй дэлхий даяар ихээхэн алдартай бөгөөд 1992 онд ЮНЕСКО-гийн дэлхийн соёлын өвд бүртгэгдэж байжээ.

## АЛЕППОД АЙМШИГ ҮРГЭЛЖИЛСЭЭР...

Б.ДАВААХҮҮ

Сирийн Алеппо хотын Катержи гэх дүүрэгт болсон бөмбөгдөлтөд өртөж, амьд мэнд үлдсэн бяцхан хүүгийн бичлэг өнгөрөгч долоо хоногт дэлхий нийтийг цочирдуулав. Тоос тортог, цусанд будагдаж хэн гэдгийг нь таних аргагүй болсон Омран Дакнеш гэх хүү бичлэгт дүрслэгдсэн байх бөгөөд тэрбээр бөмбөгдөлтийн дараа байшингийн нуруанги дороос аврагдаж, зоолоор амьд үлджээ. Хүү таван настай. Сирийн иргэний дайн ч эхлээд эдүгээ таван жилийн нүүрийг үзсэн байна. Харин хүүгийн эмнэлгийн тусламж авахаар өрөвдөлтэй гэгч нь сууж буй зураг хүйтэн дайны утаан дунд амьдарч буй сирн хүүхдүүдийн дүр зургийг дэлхий дахинаа харуулж чадсан юм. Турктай хиллэх Сирийн хойд этгээдийн Алеппо хот 2007 оны байдлаар 4.393 сая хүн амтай тус улсын томоохон хотуудын нэг байлаа. Харин эдүгээ дайны утаа суунаглаж, гэм зэмгүй энгийн иргэд амиа алдсан “цусан

...Турк руу эцэг эхийнхээ хамт дүрвэх замдаа живж амиа алдсан байдаг. Түүний цогцос Туркийн эрэгт шидэгдэж, улмаар нэгэн сэтгүүлч зургийг нь авч, нийгмийн сүлжээгээр цацсан нь дэлхий нийтийг мөн л цочирдуулж байсан удаатай...

хот” болж хувирчээ. Цагтаа 4.3 сая хүн амтай байсан эл хотод хамгийн сүүлд авсан мэдээгээр 700 мянга хүрэхтэй үгүйтэй хүн амьд үлдэхийн төлөө тэмцэж байна. Таван жилийн өмнө 2011

оны гуравдугаар сард “Арабын хавар” нэртэй Хойд Африк, Ойрхи Дорнодыг орнуудыг эмх замбараагүй, үймээн самуунд дууссан давалгаа Сири улсыг ч тойроогүй. Үүнд Алеппо хот хамгийн ихээр өртөж, хүн төрөлхтний түүхэн дурсгалт барилга байгууламж хүн зоноо алдаад дуусч буй нь энэ. Сирийн хүний эрхийн байгууллагын мэдээлснээр өнгөрсөн гурван долоо хоногийн дотор л гэхэд 300 гаруй энгийн иргэн амиа алджээ. Одоогийн байдлаар мужийн зүүн хэсэгт босогчид хяналтаа тогтоосон бол баруун этгээдийг Сирийн Засгийн газрын арми хянаж буй. Сөргөлдөгч талууд босогчид болон арми гэсэн хоёр хэсэгт хуваагдаж, нэг нэг рүүгээ давших бөгөөд энэ мөргөлдөөн дунд энгийн иргэд хохирч, сар хүрэхгүй хугацаанд 300 гаруй хүн нас баржээ. Эртний түүх дурсгалын Пальмир хотыг хэт даврагчдаас чөлөөлсөн Сирийн арми өнгөрөгч гуравдугаар сараас эхлэн Алеппо хотыг чөлөөлөх дайралтаа эхлүүлсэн байдаг.

мянга нь хүүхдүүд аж. Тэдгээр хүүхдүүд Омран Дакнеш хүүгийн адил орчинд амь өрсөж буй бол эцэг эхийнхээ хамт Газар дундын тэнгисийг гатлан дүрвэх бяцхан хүүхдүүд ч яг адил эрсдэлтэй тулгардаг. Үүний нэг жишээ нь, гурван настай Аль Курди хүү. Тэрээр Турк руу эцэг эхийнхээ хамт дүрвэх замдаа живж амиа алдсан байдаг. Түүний цогцос Туркийн эрэгт шидэгдэж, улмаар нэгэн сэтгүүлч зургийг нь авч, нийгмийн сүлжээгээр цацсан нь дэлхий нийтийг мөн л цочирдуулж байсан удаатай. Тэд бол үлдэх, явах гэсэн аль ч сонголтыг хийсэн “амиа алдах” хүнд сорилттой тулгаран амьдарч буй сирн жаалуудын зөвхөн нэгэн жишээ юм. НУБ-ын мэдээллээр өдөр бүр 5000 сирн иргэн улсаасаа дүрвэдэг бөгөөд дүрвэгчдийн талаас илүү хувь нь 18-аас доош насныхан байдаг байна. Түүнчлэн, Сирийн иргэний дайн эхэлснээс хойш нийтдээ 290 мянган хүн амь үрэгдсний 15000 мянга нь гэм зэмгүй хүүхдүүд байжээ.

## Туркийн Ерөнхийлөгч “Лалын улс” бүлэглэлийг сэжиглэв

Туркийн зүүн өмнөд этгээд дэх Сирийн хилийн ойролцоо орших Газиантеп зохион байгуулагдсан хуримын ёслолын үеэр дэлбэрэлт болж, 30 хүн барч, 94 хүн гэмтэж бэртжээ. Улмаар тус улсын Ерөнхийлөгч Ресеп Тайип Эрдоган эл хэрэгт “Лалын улс” бүлэглэлийг сэжиглэж, хариуг нь барина гэдгээ сануулсан байна. Хуримын ёслолын үеэр болсон дэлбэрэлтийг амиа золиослогч этгээд үйлдсэн байх магадлалтай аж. Хуримын ёслолын үйл ажиллагааг онилсон террорист ажиллагаа энэ сарын 20-ны шөнө болжээ. Ресеп Тайип Эрдоган дээрх хэрэгт “Лалын улс” бүлэглэлийг хардаж буй бөгөөд цэргийн эргэлт хийхийг завдсан этгээдүүдтэй тус бүлэглэл

холбоотой гэж үзэж буйгаа мөн илэрхийлсэн байна. Тэрбээр цэргийн эргэлтийг хөшигний араас удирдсан хэрэгт сэжиглэгдэж байгаа Фетуллах Гулиныг дэмжигчид болон Курдын босогчид, энэ удаа халдлага үйлдсэн “Лалын улс” бүлэглэлийнхэн хоорондоо холбоотой байх нь гарцаагүй хэмээн мэдэгджээ. НАТО-ын гол бүрэлдэхүүн улсын нэг гэгддэг Туркад энэ он гарснаас хойш курдын босогчид болон “Лалын улс” бүлэглэлийнхэн удаа дараа халдлага үйлдэх болсон байдаг. Түүнчлэн өнгөрсөн сарын 15-нд тус улсын армийн зарим эрх мэдэлтнүүд цэргийн эргэлт хийхийг завдсанаар Туркийн байдал тогтворгүй болж эхэлсэн юм.

## Миамид жирэмсэн эмэгтэйчүүд зорчихыг хоригложээ

АНУ-ын халдварт өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төв тус улсад аялал жуулчлалаараа алдартай Флорида мужийн Миами далайн эргийн хотод жирэмсэн эмэгтэйчүүд ирэхгүй байхыг анхааруулжээ. Миамид сүүлийн үед шумууланд хазуулж, зика вирусийн халдвар авсан иргэдийн тоо нэмэгдэж буйтай

холбоотойгоор дээрх арга хэмжээг авч буй аж. Түүнчлэн Өвчнийг хянах урьдчилан сэргийлэх төв жирэмсэн эмэгтэйчүүдийг зөвхөн хот бус Миамигийн бүс нутагт ирэхгүй байхыг санал болгож байгаа юм байна. Хамгийн сүүлд авсан мэдээллээр Флорида мужид шумууланд хазуулж, зика вирусийн халдвар

авсан хүний тоо 36 тохиолдол болж нэмэгдсэн бөгөөд Миами далайн эргийн хотод таван тохиолдол бүртгэгдсэн байна. Өвчний халдварыг тархаагүй байх үүднээс Флорида мужийн Эрүүл мэндийн яам Миами Дейдэд хоргон шавьж устгах үйл ажиллагааг эрчимжүүлээд байгаа аж.

PC mall.

Стив Жобс бол дижитал хөгжмийн анхдагч юм. Түүний бидэнд үлдээсэн зүйл бол агуу. Гэхдээ тэр гэртээ хариад пянз л сонсдог байсан....

-Neil Young

HELP!  
6 August 1965

With the Beatles  
(22 November 1963)

A Hard Day's Night  
10 July 1964

stereo

7575-3535
www.pc-mall.mn
PCmallOfficial

## ТАЛАРХАЛ

Бидний хайрт аав Монголын төмөр замын ууган ажитан Тугчин овогт Мөнтгөрын Жадамбаа нь 87 насандаа ертөнцийн мөнх бусыг үзүүлж бидэнд хүнд гарз тохиолдсон билээ.

Бидэнд сэтгэл санааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн дараахь байгууллага хамт олонд чинь сэтгэлийн талархал илэрхийлье.

1. Улаанбаатар хотын банк
2. Дархан төмөрлөгийн үйлдвэр ХК
3. Эрдэнэт үйлдвэр ХХК
4. НИММ аудит ХХК
5. Монголын өмгөөлөгчдын холбоо
6. Монголын архитекторын эвлэл
7. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар,
8. Нийслэлийн эрүүл мэнд нийгмийн даатгалын газар,
9. Улаанбаатар ТЗ-ын ахмадын хороо
10. Чойр өртөөний ахмадын хороо болон бусад байгууллага хамт олон, найз нөхөд, төрөл төрөгсөд та бүхний амьдрал, ажилд өндөр амжилт хүсэн ерөөе.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай.

Ум сайн амгалан болтугай.

Жанжин чойр овогт Жадамбаагийн Эрдэнэбилэг болон түүний гэр бүл, ахан дүүс, төрөл төрөгсдөөс.

2016 оны 08 сарын 19 өдөр



# ШУУРХАЙ МЭДЭЭ

120 мянган хүн элэгний С вирусстэй гэв

## Я.БАЙГАЛМАА: 765 ХҮҮХЭД ХАРАГЧ БЭЛТГЭСЭН

Н.БАТЗАЯА

*Хүүхэд харах үйлчилгээний талаар Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын дарга Я.Байгалмаагаас зарим зүйлийг тодрууллаа.*

**-Хүүхэд харах үйлчилгээ хэрэгжиж эхлээд нэлээд хугацаа өнгөрсөн байна. Энэ жил хэчнээн хүн үйлчилгээний эрх авсан бэ?**

“Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль” энэ оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Уг хуулийг хэрэгжиж эхэлснээс хойш дөрвөн сарын хугацаанд

түрүүнд хэлсэн. Тэгэхээр улсын болон хувийн цэцэрлэгт хамрагдаж чадаагүйгээс болж гэртээ харах хуугүй ганцаараа үлддэг нийт 3000 орчим хүүхэд уг үйлчилгээнд хамрагдах боломжтой. Ирэх сарын 1-н гэхэд 3000 хүүхэд сургуулийн өмнөх боловсролыг хүүхэд харах үйлчилгээгээр дамжуулан авах юм. Мөн Хүн амын хөгжил, нийгэм хамгааллын яамнаас 2015-2016 онд нийслэлийн хэмжээнд 5913 хүүхдийг хүүхэд харах үйлчилгээнд хамруулах квот өгсөн байдаг.

**-Зарим нь үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн гэлээ.**

“Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно. Тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг 14 хоногийн дотор шийдвэрлэх юм. Гэхдээ үйлчилгээ эрхлэгчид сургалтад суух ёстой. Үүний дараа үйлчилгээ явуулах байраа бэлдэнэ. Тэгж байж тусгай зөвшөөрөл авах тухай асуудал яригдах юм. Мөн үйлчилгээг эрхэлж буй хуулийн этгээд Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг дахин сэргээх эрхгүйгээр хүчингүй болгох хуулийн зохицуулалт бий.

**-Хэдэн настай хүүхдүүд хамрагдах боломжтой вэ?**

Цэцэрлэгийн наснаас ерөнхий боловсролын сургуульд орохоос өмнөх насны хүүхдүүд хамрагдана. Тодруулбал, 2-7 настай хүүхдүүд хамрагдах боломжтой.

**-Зарим эцэг, эхчүүд хүүхэд харах үйлчилгээний байрны асуудалд анхаарч байна. Байр ямар байх ёстой юм бэ?**

“Хүүхэд харах үйлчилгээ явуулах зориулалтаар үйл ажиллагаа эрхэлж буй иргэний байр нь түрээсийн байр, зээлийн байр, гэр байж болно гэж хуульд заасан. Өөрөөр хэлбэл, хүүхэд харах төвүүд түрээсийн, зээлийн байр, монгол гэрт үйл ажиллагаа явуулж, хүүхэд хүлээн авч болно гэсэн үг. Харин үйл ажиллагаа явуулж байгаа байр нь хүүхдийн амь нас, эрүүл мэндэд эрсдэлгүй, хүүхэд аливаа болзошгүй сөрөг нөлөөлөл, үйлдлээс хамгаалагдсан хэвийн нөхцөлийг хангасан байх нь чухал юм. Мөн үйлчилгээний байр нь хүүхэд амрах, тоглох, гар угаах, бие засах газар, гал тогоотой байх ёстой. Хэрвээ гэрт зохион байгуулах тохиолдолд гал тогооны тусдаа гэртэй байхаас гадна гэрийн халаалт, гэрэлтүүлгээс хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, гэрт ил задгай зуух, халаалтын хэрэгслийг хүүхдээс тусгаарлах ёстой.

...Хүүхэд харах үйлчилгээ явуулах зориулалтаар үйл ажиллагаа эрхэлж буй иргэний байр нь түрээсийн байр, зээлийн байр, гэр байж болно гэж хуульд заасан. Өөрөөр хэлбэл, хүүхэд харах төвүүд түрээсийн, зээлийн байр, монгол гэрт үйл ажиллагаа явуулж, хүүхэд хүлээн авч болно гэсэн үг...

хуулийн бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Ингээд тавдугаар сарданхны үйлчилгээг эзүүлж эхэлсэн. Өнгөрсөн хугацаанд нийслэлийн хэмжээнд 765 хүүхэд харагчийг бэлтгэлээ. Сургалтад хамрагдсан 765 хүүхэд харагчаас 389 нь байрны дүгнэлтээ гаргаж өгсөн. Эдгээр хүмүүс үйл ажиллагаагаа эхлүүлсэн байгаа.

**-Улсын цэцэрлэгүүд зун амарсан шүү дээ. Гэтэл зун ажилладаг хүмүүс байдаг. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчид зун ажилласан уу?**

“Улсын баяр наадам, АСЕМ болон зуны амралт эхэлсэнтэй холбогдуулан хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчид зургадугаар сарын 1-нээс эхэлж амарсан. Есдүгээр сарын 1-нээс хэвийн үйл ажиллагаагаа явуулж эхэлнэ.

**-Энэ хичээлийн жилд хүүхэд харах үйлчилгээнд хэчнээн хүүхэд хамрагдах боломжтой вэ?**

“Энэ жил 765 хүүхэд харагчийг бэлтгэсэн гэж би

**Одоогийн байдлаар хэчнээн хүүхэд хамрагдаад байна вэ?**

“Одоогийн байдлаар 389 хүүхэд харах үйлчилгээнд нийслэлийн хэмжээнд нийт 1885 хүүхэд хамрагдсан. Есдүгээр сарын 1 гэхэд 3000 хүүхэд болно.

**-Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчид хэдэн хүүхэд авах боломжтой вэ?**

“Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль”-д хүүхэд харагч нь бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой, хүүхэд харах үйлчилгээний тусгай сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан 18-65 насны Монгол Улсын иргэн байна гэж заасан. Мөн нэг иргэн таваас дээш хүүхэд харахгүй. Гурван иргэн хамтраад нэг дор 15 хүүхэд харж болно гэж хуулийн зохицуулалт хийж өгсөн байдаг. Тэгэхээр нэг хүүхэд харагч доод тал нь таван хүүхэд л харна гэсэн үг.

**-Хүүхэд харах үйлчилгээ эрхлэхийг хүсч буй иргэд байгаа. Тэр хүмүүс яаж уг үйлчилгээг эрхлэх эрх авах вэ?**

Хар тамхины төрөл каннабисын худалдаа ихэсчээ

Энэ оны долоо, наймдугаар сард хар тамхи, мансууруулах бодистой холбоотой 23 холбогдогчтой 10 гэмт хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулжээ. Эдгээр хэргийн ихэнх хувийг мансууруулах үйлчилгээтэй ургамлын төрөлд орох каннабисыг түүж, бэлтгэн, боловсруулж бусдад зарж боловсруулсан гэмт хэрэг эзэлж байгаа гэдгийг Цагдаагийн газраас мэдээллээ. Эрүүгийн цагдаагийн газрын Хар тамхитай тэмцэх хэлтсээс 2016 оны долдугаар сарын 29-ны өдөр Т, Б, С, Г нар нь бүлэглэн мансууруулах бодисын төрөлд орох ICE буюу мөснийг бусдад зарж борлуулах зорилгоор авч явж байсныг илрүүлэн ЭХТА-ийн

192-192.2-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байна. Дээрх этгээдүүдийн гурав нь давтан гэмт хэрэгт холбогдсон бөгөөд иргэн Г нь өмнө нь хар тамхины хэргээр ял шийтгүүлж байсан болох нь тогтоогджээ. Мөн энэ оны наймдугаар сарын 17-ны өдөр П нь мансууруулах үйлчилгээтэй ургамлын төрөлд орох каннабисыг их хэмжээгээр түүж бэлтгэн, бусдад зарж борлуулах зорилгоор авч явж байсныг илрүүлэн ЭХТА-ийн 192-192.2-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлжээ. П, Б, Т нарыг ШШГЕГ-ын хорих 0461 дүгээр ангид сэжигтнээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч мөрдөн байцаалтын ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байна.

### СЭРЭМЖЛҮҮЛЭГ

#### Зам тээврийн ослоос болгоомжил

Өнгөрсөн баасан гарагт Улаанбаатар хотын Замын цагдаагийн газрын ЖШУХ-т зам тээврийн ослын 233 дуудлага бүртгэгдсэн байна. Ослын улмаас гурван хүний амь нас хохирч, 22 хүн хүнд хөнгөн гэмтжээ. Тодруулбал, Чингэлтэй дүүргийн нутаг Зуслангийн зам, Зунжин дэлгүүрийн баруун урд замд Subaru Impreza маркийн авто машины жолооч Т нь Т.Allion маркийн Ө жолоочтой авто машинтай мөргөлдөж, жолооч 31 настай эрэгтэй Ө, 29 настай эрэгтэй Т нарын амьс хохирчээ. Мөн зорчигч 14 настай эмэгтэй У нарын хоёр хүн гэмтсэн байна. Түүнчлэн Сонгинохайрхан дүүргийн нутаг Товчооны зам, Everdigm Doosan ХХК-ны хойд замд Н.Starex маркийн авто машины жолооч Б нь явган зорчигч 56 настай эрэгтэй 3-г мөргөж амийг нь хохироосон аж. Тиймээс замын хөдөлгөөнд болгоомжтой оролцохыг Замын цагдаагийн газраас анхаарууллаа.

#### Монгол, Хятадын сэтгүүлчдийн форум болов

Монгол, Хятадын хэвлэл мэдээллийн VII форум энэ сарын 19-21-нд Хэнтий аймагт болж өндөрлөлөө. Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөр 2013 оноос хэрэгжсэн. Энэ хөтөлбөрийн хүрээнд хоёр орны хэвлэл мэдээллийн байгууллагуудын солилцоо, хэвлэл мэдээллийн форумыг жил бүр зохион байгуулдаг уламжлал тогтоод байгаа юм. Уг уламжлалын дагуу 2015 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алшаа аймагт хоёр улсын сэтгүүлчдийн форумыг зохион байгуулсан. Тус форумар

Ази, Европыг холбосон эдийн засгийн коридорыг байгуулах ямар боломж буйг хоорондоо хэлэлцэж, энэ сэдэвтэй холбоотой мэдээ мэдээллийг хоёр улсын хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчид туштай хөндөн бичиж эхэлжээ. Харин энэ жил манай улсад зохион байгуулж буй VII форумар Монгол, Хятадын харилцаа, хоёр улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагааны асуудлыг хөндсөн аж. Форумд нийт 10 илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлжээ. Тус форумд хоёр талын 90 гаруй төлөөлөгч оролцжээ.

### PHOTO NEWS



Нийслэлийн Засаг дарга С.Батболд сургууль, ичирлэгийн барилгын үйл явцтай өнгөрсөн баасан гарагт танилцлаа. Тэрбээр, Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо буюу Хайлаастын эцэст байрлах ичирлэг, бага сургуулийн цогцолбор барилга, Баянзүрх дүүргийн 13 дугаар хороонд байрлах 14 дүгээр сургуулийн барилга, Сүхбаатар дүүргийн IV дүгээр хороонд байрлах нэгдүгээр ичирлэгийн өртөөгийн барилга болон Баянгол дүүргийн 18 дугаар хороонд байрлах 11 дүгээр ичирлэгийн барилгын ажлын явцтай танилцсан юм.



Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

#### АТГ цэцэрлэгийн бүртгэлийг хянана

Нийслэлийн хэмжээнд энэ жил шинээр 30 гаруй сургуулийг ашиглалтад оруулж, сургуулийн хүчин чадал 3040 суудлаар нэмэгдэх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Энэ хүрээнд есдүгээр сарын 1-10-ны хооронд сурагчдаа хүлээн авах долоон бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгын ажил дуусч, үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн болжээ. Гэвч шилжилт хөдөлгөөн, хүн амын хэт төвлөрлөөс хамаарч,

цэцэрлэгүүд ачааллаа даахгүй, нэг ангид хичээллэх хүүхдийн тоо стандартгаасаа давах асуудал жил бүр гардаг. Энэ үеэр авлига өгч, авдаг гэсэн гомдол их гардаг учраас Авлигатай тэмцэх газартай хамтран хяналт тавьж ажиллахаар болжээ. Түүнчлэн энэ жил нийслэл дэх цэцэрлэгүүдийн суудлын тооны 20 хувийг зорилготой бүлэг, 80 хувьд нь тусгай талон тарааж, сугалаа явуулахаар болоод байгаа юм.

#### Адууны махны экспорт 40.7 хувиар нэмэгдэв

Монгол Улс оны эхний долоон сарын хугацаанд 3.9 сая ам.долларын адууны мах экспортолсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 40.7 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа аж. Харин тоо хэмжээний хувьд жилийн өмнөхтэй харьцуулахад 66 орчим хувиар өсч, 2100 орчим тонн болсон талаар Үндэсний статистикийн хорооноос мэдээллээ. Монгол Улсын хувьд адууны махаа голчлон ОХУ-д экспортолдог. Манай улс махны экспортоо дэмжихээр зорьж байгаа бөгөөд дийлэнхийг нь ОХУ, БНХАУ, Казахстан улсад гаргаж байгаа юм. Түүнчлэн Вьетнам мах экспортолох зөвшөөрлийг “Мах маркет”, “Хатан сүйх импекс”, “Дархан мах экспо”, “Перком” компаниудад олгожээ. Энэ онд БНХАУ-ын мэргэжлийн хяналтынхны шинжилгээгээр шүлхий өвчингүй болохыг нь тогтоосон баруун таван аймагас дотоодын гурван компанид БНХАУ-д хонь, ямааны мах экспортолох зөвшөөрөл олгосон байна. Мөн өнгөрсөн баасан гарагт “Хатансүйх” компани дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнийг БНХАУ-д, үхрийн ясны өтгөрүүлсэн шөл бүтээгдэхүүнийг БНСУ-д экспортолож эхэллээ. “Хатансүйх” компани Монгол Улсаас БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн экспортолох зөвшөөрөл авсан дөрвөн компанийн нэг бөгөөд БНХАУ-д бүтээгдэхүүнээ экспортлож байгаа нь анх удаагийнх гэдгээрээ онцлог ажээ.



# ЗАВСАРЛАГА



## Д.Сумъяаг

# ХӨДӨЛМӨРИЙН БААТАР ЦОЛ ӨГЬЕ

...Д.Сумъяа тэр хэмжээний амжилтыг үзүүлчихээд ирлээ. Тийм болохоор улс өгөх ёстой цол хэргэмээ өгөх байлгүй дээ. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж аль хэдийнэ энэ талаар бодолцоод, Д.Сумъяаг Хөдөлмөрийн баатар цол өгөх бэлтгэлээ хангачихсан байлгүй дээ...

### Н.ПУНЦАГ

Бразилын Рио хотноо болсон зуны Олимпын 31 дүгээр наадам өндөрлөлөө. Монголын баг тамирчид энэ удаагийн Олимпын наадамд 43 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон нь түүхэн амжилт байсан юм. Харамсалтай нь манайх харьцангуй олон тамирчнаа Рио руу илгээсэн ч Бээжин, Лондоны Олимпын наадмын амжилтдаа хүрсэнгүй. Жүдогоос эмэгтэйчүүдийн 57 кг-д барилдсан Д.Сумъяа мөнгөн медаль хүртсэн нь Монголын тамирчдын нүүрийг тахаллаа. Боксоос Д.Отгондалай финалдах боломж байсан ч шүүлтгийн маргаантайгаар ялагдаж, хүрэл дээр л буулаа. Чөлөөтөөс Г.Мандахнаран, Д.Хүдэрбулга нар барилдаагүй,



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

марафоны эрэгтэйчүүд гүйгээгүй байхад бичсэн гэдгийг хэлэх хэрэгтэй байх. Тэгэхээр үндсэндээ Д.Сумъяа энэ удаагийн Олимпын наадамд хамгийн өндөр амжилт үзүүлсэн тамирчин боллоо. Эмэгтэй жүдогийнхноос анх удаа Олимпын наадмаас медаль хүртлээ, тэр нь мөнгө. Тэрбээр өнгөрсөн баасан гарагт эх орондоо ирсэн. Түүнийг онгоцны буудал дээр Монголын Жүдо бөхийн холбоо, "Хилчин"

спорт хороо, Увс аймгийн нутгийн зөвлөлийнхөн болоод гэр бүлийнхэн, найз нөхөд нь баатарын ёсоор угтаж авсан. Мөн Боловсролын сайдаас авахуулаад албаны хүмүүс ч хүлээж авч, хүндэтгэл үзүүлж байгаа. Түүрчлэн зарим хүмүүс байр сав амлаад эхэллээ. Тухайлбал, Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил хувиасаа гурван өрөө, бүрэн тавилгатай байр өгөхөөр амласан байсан. Энэ мэтээр түүний хөдөлмөр

зүтгэл, гавьяаг, эх орныхоо нэрийг Олимпын дэвжээнд дуурсгасан амжилтыг үнэлж эхэллээ. Одоо төр засаг ч гэсэн амжилт гаргасан тамирчнаа үнэлэх хэрэгтэй байна. Тэрбээр мастеруудын тэмцээнд гурав түрүүлж, Дэлхийн аваргаас хүрэл медаль авч байж Гавьяат тамирчин цол хүртсэн. Тэгвэл одоо Олимпын наадмын мөнгөн медаль хүртсэн амжилтыг нь үнэлээд Хөдөлмөрийн баатар цолоо өгөх л хэрэгтэй. 2008

оны Бээжингийн Олимпын наадмаас О.Гүндэгмаа мөнгөн медаль хүртэж байхад түүнд Хөдөлмөрийн баатар цол өгч байсан. Тэгвэл Д.Сумъяа тэр хэмжээний амжилтыг үзүүлчихээд ирлээ. Тийм болохоор улс өгөх ёстой цол хэргэмээ өгөх байлгүй дээ. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж аль хэдийнэ энэ талаар бодолцоод, Д.Сумъяаг Хөдөлмөрийн баатар цол өгөх бэлтгэлээ хангачихсан байлгүй дээ.

Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр +20  
Шөнө +11

Нөгөөдөр  
Өдөр +16  
Шөнө +7



Аргын тооллын:  
2016 оны 08-р сарын 22,  
Даваа гараг

Билгийн тооллын:  
Шинийн 19 Дөрвөн долоон  
улаан тэнгэстэй Улаан хулгана  
өдөр

Наран ургах/шингэх:  
06:59 / 20:52

Үс засуулбал:  
Сайн нөхөртэй нөхөрлөнө.



Тухайн өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамирыг сэргээх, гарагийг тахиж, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улаа гаргах, хиншүү хярвас гаргах, төлөг тавих, морь уралдахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал "Сайн нөхөртэй учирах" хэмээх сайн.

## Райан Лохте бразилчуудаас уучлалт гүйв

Б.ДАВААХҮҮ

Олимпын наадамд оролцохоор Бразилын Рио де Жанейро хотноо очоод дээрэмдүүлсэн хэмээн дуулиан тариад байсан Америкийн усанд сэлэлтийн шигшээ багийн тамирчин, 32 настай Райан Лохте нийт бразилчуудаас уучлалт хүсчээ. Тэрбээр Глобо гэх телевизээд өгсөн ярилцлагадаа дээрх хэргийн талаар дурдаж миний алдаа хэмээн уучлалт гуйжээ. Олимпоос нийтдээ зургаан алтан медаль хүртсэн усанд сэлэлтийн суут тамирчин эр телевизийн нэвтрүүлэгт өгсөн ярилцлагынхаа үеэр "Би маш их харамсч байна. Ийм зүйл дахиад давтагдах ёсгүй. Энэ миний алдаа" хэмээн ярьжээ. Хэргийг эргэн сануулбал, Райан Лохте тэргүүтэй Америкийн усанд сэлэлтийн спортын дөрвөн тамирчин Рио хот дахь тамирчдын тосгон руу буцаж явахдаа бүлэг этгээдүүдэд дээрэмдүүлсэн хэмээн цагдаад гомдол гаргаж томоохон дуулианыг дэгдээсэн юм. Гэвч уг мэдүүлэг худал болох нь тогтоогдож, эцэстээ тамирчин өөрөө бразилчуудаас уучлалт гуйжээ.

## Тасалбар дамласан Патрик Хикки Риогийн шоронд хоригджээ

Риогийн зуны олимпын тасалбарыг дамлан худалдах зорилго бүхий хууль бус сүлжээг байгуулсан гэх хэрэгт сэжиглэгдэж буй Ирландын Олимпын хорооны ерөнхийлөгч Патрик Хикки Рио Де Жанейро хотын шоронд хоригджээ. Түүнтэй холбоотой дуулиан Риогийн зочид буудлаас 1000 орчим тасалбар олдсоноор

эхэлсэн байдаг. Хикки эдүгээ 71 настай бөгөөд түүний байгуулсан хууль бус сүлжээ олимпын наадмын тасалбарыг анхны үнээс нь тав дахин өндөр үнээр борлуулж байсан нь мөрдөн шалгалтаар тогтоогдсон аж. Тодруулбал, Олимпын нээлтийн ёслолын тасалбарыг 8000 хүртэлх доллароор борлуулж байсан бол хаалтын ёслолын тасалбарыг

15 мянга хүртэлх доллароор борлуулж байсан байна. Патрик Хикки Ирландын Олимпын хорооны тэргүүнээс гадна Европын Олимпын хорооны гишүүн болон Олон улсын Олимпын хорооны Удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан юм. Гэвч дээрх дуулиантай холбогдуулан тэрбээр бүх албан тушаалаасаа огцорчээ.

## Хятадын волейболчид гурав дахь удаагаа олимпод аваргалав

Бразилын Рио де Жанейро хотноо зохион байгуулагдаж буй 31 дэх удаагийн зуны олимпын эмэгтэй гар бөмбөгийн тэмцээнд Хятадын шигшээ баг аваргалжээ. Алтан медалийн төлөөх тоглолтыг Хятадын баг Сербийн шигшээтэй хийсэн бөгөөд 3:1 харьцаатайгаар

буулгаж авчээ. 1984 оны Лос Анжелесын Олимп, 2004 оны Афины олимпоос тус тус алтан медаль хүртэж байсан Хятадын волейболын шигшээ 1996 оны Атлантагийн олимпод ч гэсэн Кубын багт ялагдан мөнгөн медаль хүртэж байсан юм. Тэгвэл энэ удаа тэд амжилтынхаа тоог

ахиулж энэ төрлийн спортод хамгийн амжилттай яваа Сербийн багийг ялж, олимпын гурав дахь алтаа хүртлээ. Харин хүрэл медалийг АНУ-ын шигшээ хүртсэн байна. Хүрэл медалийн төлөө Нидерландын багтай тоглосон АНУ-ын тамирчид 3:1 харьцаагаар ялалт байгуулжээ.



## Усэйн Болт Олимпын ес дэх алтан медалиа хүртлээ

Алдарт Усэйн Болт тэргүүтэй Ямайкийн гүйгчид Риогийн Олимпын эрэгтэйчүүдийн 4x100 м-ийн буухиа гүйлтэд алтан медаль хүртлээ. Усэйн Болт, Асафа Пауэлл, Йохан Блейк болон Никель Ашмидын дөрвөл 4x100 м-ийг 37.27 секундэд туулан алтан медаль хүртсэн байна. Ингэснээр Болт Риогийн Олимпоос гурав дахь алтан медалиа, Олимпоос нийтдээ ес дэх алтан медалиа хүртлээ. Болт үүний өмнө Риогийн Олимпын 100 болон 200 метрт түрүүлээд байсан юм. Ингэснээр тэрбээр 100, 200 болон 4x100 м-т гурвууланд нь түрүүлэн "Бээжин-2008" болон "Лондон-2012"-ын амжилтаа давтлаа. Харин Японы баг 4x100 м-т 37.60 секундээр хоёрдугаар байрт орсон бол АНУ-ын баг 37.62 секундээр гуравдугаар байрт орсон боловч хүрэл медалийг дөрөвдүгээрт байрт орсон Канадын багт өгсөн байна. Учир нь АНУ-ын багийн гүйгч Майк Рожерсоос буухианы саваа модыг Жастин Галтлин хэтэрхий эрт авсан гэж шүүгчид үзжээ.

### ТЭНГИС КИНО ТЕАТР

Засгийн газрын нууц агентлаг маш нууц ажлыгаа явуулахын тулд шоронд хоригдож байгаа онц ноцтой гэмт хэрэгтнүүдэд өршөөл үзүүлэхээр амлаж золиосны суман бүрдүүлнэ.

Нэгэн залуу хайр дурлалынхаа төлөө өглөө бүр хийдэг дадал зуршил болсон гэнэтийнхээ бэлгийг хайртай охиндоо барьснаар киноны үйл явдал эхэлнэ. Үүнээс үүдэж өөр хайр дурлалтай учирна. Энэ хайр дурлалыг нь хоёр найз нь эсэргүүцэж киноны үйл явдлыг өрнүүлж асуудлыг улам хурцдуулна.

УДАХГҮЙ ТЭНГИСИЙН ДЭЛГЭЦНЭЭ